13.5 Төгсөлтийн бүртгэл

ТӨГСӨЛТИЙН БҮРТГЭЛ

5-р ангийн төгсөлтийн бүртгэлийг сургалтын менежер баталгаажуулах эсвэл цуцалж болно.



Бүртгэлийн явцаас хамаарч 5-р ангийн төгсөлтийн бүртэлийн төлөв нь дараах байдлаар өөрчлөгдөнө.

№	Үйл ажиллагаа	Төлөв
1	АУБ төгсөлтийн бүртгэл хийгээгүй.	Бүртгээгүй
2	АУБ төгсөлт бүртгэсэн.	Бүртгэсэн
3	АУБ төгсөлтийн бүртгэлийг Менежерт илгээсэн.	Илгээсэн
4	Менежер төгсөлтийн бүртгэлийг Баталгаажуулсан. Баталгаажуулах	Батлагдсан
5	Менежер төгсөлтийн бүртгэл цуцалсан.	Цуцлагдсан



1. Төгсөлт баталгаажуулах, эсвэл цуцлах суралцагчийг сонгоно.
2. "Баталгаажуулах хүсэлт" товч дээр дарахад "илгээгдсэн" хүсэлтийг "хянагдаж байгаа" төлөвт шилжүүлнэ.
3. "Баталгаажуулах" товч дээр дарахад "илгээсэн" болон "хянагдаж байгаа" хүсэлтийг "Батлагдсан" төлөвт шилжүүлнэ.
4. "Цуцлах" товч дээр дарахад хүсэлтийг "цуцлагдсан" төлөвт шилжүүлнэ.

9, 12-р анги төгсөгчдийн хувьд дараах дарааллын дагуу бүртгэлийг хөтөлж, баталгаажилт хийнэ.



Бүртгэлийн явцаас хамаарч төлөв нь дараах байдлаар өөрчлөгдөнө.

№	Үйл ажиллагаа	Төлөв
1	АУБ төгсөлтийн бүртгэл хийгээгүй.	Бүртгээгүй
2	АУБ төгсөлт бүртгэсэн.	Бүртгэсэн
3	АУБ төгсөлтийн бүртгэлийг Менежерт илгээсэн.	Илгээсэн
4	Менежер төгсөлтийн бүртгэлийг БСУГ/БХ –д илгээсэн.	Хянагдаж байгаа
5	БСУГ/БХ –ийн мэргэжилтэн төгсөлтийн бүртгэлийг хянасан.	Хянагдсан
6	БСУГ/БХ –ийн Дарга төгсөлтийн бүртгэлийг баталгаажуулсан. БҮ/БГ дугаар болон QR код олгогдоно.	Батлагдсан
7	Төгсөлтийн бүртгэл цуцлагдсан.	Цуцлагдсан

Сургууль дээрээс баталгаажуулах хүсэлт илгээхэд анхаарах зүйлс

- “Бүртгэлийн маягт” хянана.
- Суралцагч бүрээр төгсөлтийг баталгаажуулна.
- Сургуулиас дүүргийн БХ –т “Төгсөлт баталгаажуулах хүсэлт” илгээсэн үед дараах бүртгэлүүд засварлах боломжгүй болно.
    - Хичээлийн дүн
    - Судлагдахууны дүн